


Үзүүлэлтүүд:

<p>ДНБ 1.4% 2016 оны II-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр</p>	<p>ГШХО 6-р сард -735.5 сая ам.доллар</p>	<p>Төсвийн алдагдал -1.9 их наяд төгрөг</p>	<p>Инфляци 0.9%</p>	<p>Чанаргүй зээл 1.03 их наяд төгрөг</p>	<p>Валютын нөөц 1.2 тэрбум ам.доллар</p>
<p>Уул уурхайн салбар 9.1 хувь, барилгын салбар 4.4 хувь, хөдөө аж ахуйн салбар 3.5 хувь тус тус өссөн нь нөлөөлөв.</p>	<p>Цэвэр ГШХО 6-р сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 801.1 сая ам.доллар, өмнөх сараас 910 сая ам.доллараар буурч (735.5) сая ам.доллар болов.</p>	<p>Төсвийн орлого 3040 тэрбум төгрөг, зарлага 2014 тэрбум болж төгрөг, тэнцэл (1974.1) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.</p>	<p>Өмнөх сараас 0.6 хувь буурч, оны эхнээс 2.3 хувь өмнөх оны мөн үеэс 0.9 хувь өссөн байна.</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 0.5 хувь буюу 6 тэрбум төгрөгөөр буурч 1031 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.5% байна.</p>	<p>Монголбанкны валютын нөөц 6-р сард өнгөрсөн оны мөн үеэс 23.1 хувь буюу 389 сая ам.доллараар буурч 1297 сая ам.доллар болов.</p>
<p>\$ Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2032 ₮</p>	<p>Орон сууцны үнийн индекс 1.015 Өмнөх сараас 0.8%-иар, өмнөх оны мөн үеэс 9.6%-иар тус тус буурлаа.</p>	<p>Монголбанкны бодлогын хүү 15%</p>			

Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Үндэсний эрх чөлөөний 105, Ардын хувьсгалын 95 жилийн ойн баяр наадам 2016 оны 7-р сарын 11-15-ний хооронд өргөн дэлгэр болж өндөрлөлөө.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2014 он		2015 он		2016 оны 7-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	19.5	0.8	14.4	0.6	11.0	0.3
Төмрийн хүдэр	6.3	0.4	6.3	0.2	3.1	0.1
Зэсийн баяжмал	1.4	2.5	1.4	2.3	0.9	1.0
Нийт	27	4	22	3	15	1


Эх сурвалж: Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар

Монгол Оросын хамтарсан "Эрдэнэт" үйлдвэр 100 хувь Монгол Улсын мэдэлд шилжив. ОХУ-ын "Ростех" компанийн эзэмшиж байсан Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг ХХБ-ны төлөөний компани болох "Монголын зэс" компани эзэмшихээр боллоо.

ДНБ ДНБ 2016 оны 2-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 7.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 121.9 тэрбум төгрөгөөр өсч эдийн засгийн өсөлт 1.4 хувь болов. ДНБ-ий 1.4 хувиар өсөхөд аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 4.4 хувь, үүнээс уул уурхайн салбарынх 9.1 хувь, хөдөө аж ахуйн салбарынх 3.5 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.



Төсөв Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ долоодугаар сард 3040 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 5014 тэрбум төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1974.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 1336.2 тэрбум төгрөгөөр буурахад орлого 3.7 хувиар багасч, зарлага 32.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.




Валютын хани

Долоодугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллантай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 61.6 төгрөг буюу 3.2 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 67 төгрөг буюу 3.4 хувиар өсч 2031.9 төгрөгөөр сулрав.



Инфляци


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 7-р сард өмнөх сараас 0.6 хувь өсч, өмнөх оны мөн үеэс 0.9 хувь өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 7-р сард өмнөх оны эцсийнхээс 2.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 10.4 хувиар өссөн нь нөлөөлөв.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, Монголбанк

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 6-р сарын байдлаар 1297 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 10 хувь буюу 145 сая ам.доллараар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 23.1 хувь буюу 389 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс


2016 оны зургаадугаар сард 3.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.6 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх сарынхаас гүйлгээ 2.3 тэрбум төгрөг буюу 41.6 хувиар буурч, харин арилжигдсан үнэт цаас 0.5 сая ш буюу 39.8 хувиар өсчээ. ТОП-20 дундаж индекс 2016 оны 7 дугаар сард 12689 нэгж болж, өмнөх сарынхаас 1237 нэгжээр өсч, өмнөх оны мөн үеийнхээс 1529 нэгжээр буурчээ.



* Монголын хөрөнгийн бирж


Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2016 оны долоодугаар сарын эцэст 11.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 122.6 тэрбум төгрөг буюу 1.1 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 1448.8 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар өсөв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 818 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 21 тэрбум төгрөг буюу 2.5 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 59.1 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар өсөв.



Хадгаламж

Нийт хадгаламж 2016 оны 7-р сард 8.2 их наяд төгрөг болж өмнөх сараас 295.3 тэрбум төгрөг буюу 3.7 хувиар өссөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1014.6 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү, өмнөх оны мөн үеэс нийт хадгаламж өсөхөд валютын хадгаламж 21.2 хувиар буюу 432 тэрбум төгрөгөөр өсч, төгрөгийн хадгаламж 11.3 хувиар буюу 582 тэрбум төгрөгөөр өсчээ.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны долдугаар сарын байдлаар 12 их наяд төгрөг болж, өмнөх сараас 75 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 101 тэрбум төгрөг буюу 0.8 хувиар өсөв. Харин чанаргүй зээлийн хэмжээ 1030 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.5 хувь (6 тэрбум төгрөг)-иар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 24.9 хувь (205 тэрбум төгрөг)-иар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.5%-ийг эзэлж байна.



Ипотекийн зээл

2016 оны 7-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1.5 хувь (95.2 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 19 хувь (625.8 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.8 их наяд төгрөгт хүрэв. Долдугаар сард нийт 1716 зээлдэгчид 56.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 86622-д хүрэв. Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2016 оны 7 дугаар сарын байдлаар 3.4 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.2 байна.




Гадаад худалдаа

Гадаад худалдаа

2016 оны долоодугаар сард худалдааны нийт бараа эргэлт 4374 сая ам.доллар, үүнээс экспорт 2541 сая ам.доллар, импорт 1832 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 708 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 647 сая ам.доллар буюу 12.8 хувь, үүний дотор экспортын хэмжээ 271 сая ам.доллар буюу 9 хувиар, импортын хэмжээ 376 сая ам.доллар буюу 17 хувиар тус тус буурчээ. Эрдэс бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 85.5 хувийг эзэлж байгаа бол импортын 53.6 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт эзэлж байна.

Гадаад худалдаа




* Эх сурвалж УСХ, Монголбанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2016 оны зургаадугаар сард -735.5 сая ам.долларын сөрөг үр дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс -801.1 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад 2846 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.3 сая ам.доллар байсан бол Монгол Улсад -735.2 сая ам.долларын сөрөг үр дүнтэй хөрөнгө оруулалт хийгджээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт



* Эх сурвалж Монголбанк


Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2016 оны нэгдүгээр улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 22.5 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 11 хувь (387 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 5 хувь (995 сая ам.доллар)-иар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 18 хувийг засгийн газрын өр, 9 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 16 хувийг бусад салбаруудын өр, 48 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 97 хувийг богино хугацаат, 3 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



* Эх сурвалж Монголбанк

- 07.08 УИХ-ын чуулганаар Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайдаар Ж.Эрдэнэбатыг томилов. Ерөнхий сайдаар томилох тухай санал хураалтанд 70 гишүүн оролцсоноос 68 нь зөвшөөрөв.
- 07.15-16 Ази-Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт 2016 оны 7 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод “АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоотой байж ирээдүйн төлөө түншлэх нь” сэдвийн дор болж өнгөрлөө. Уулзалтад Ази, Европын 51 орны төр, засгийн тэргүүн буюу тэдний өндөр түвшний бие төлөөлөгчид, Европын Зөвлөлийн Ерөнхийлөгч, Европын Комиссын Ерөнхийлөгч, АСЕАН-ы Ерөнхий нарийн бичгийн дарга нар оролцлоо. Дээд түвшний уулзалтыг Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж даргалав.
- 07.17-18 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ 2016 оны 7 дугаар сарын 17-18-ны өдөр Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ-гийн албан ёсны айлчлал хоёр орны “Иж бүрэн түншлэл”-ийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, иргэд харилцан солилцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Тойм

2016 оны эхний хагас жилд гашуунсухайт боомтоор 4.3 сая тонн нүүрс экспортолжээ

2016 оны эхний хагас жилд Гашуунсухайт боомтоор 4.36 сая тонн нүүрс экспортод гаргасан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 23 хувиар өссөн дүн болж байгаа ба БНХАУ-д нүүрсний олборлолт буурч байгаа нь Монголын нүүрсний эрэлтийг нэмэгдэхэд голлон нөлөөлжээ. Нийлүүлэлт нэмэгдэж байгаагаас гадна Гашуунсухайт боомтын агуулах дахь нүүрсний нөөц хоёр сар дараалан буурсан нь эрэлт өндөр байгаагийн баталгаа болж байгаа аж. Тавдугаар сарын дүнгээр нийт коксжих нүүрсний импортынх нь 46 хувийг Монгол Улс хангаад байгаа бөгөөд тоон үзүүлэлтээр нь аваад үзвэл нийт 2.07 сая тонн нүүрс нэг сарын дотор экспортолсон нь урьд өмнө байгаагүй өндөр үзүүлэлт болжээ. Хэдийгээр экспортын хэмжээ өндөр байгаа ч үнийн дүнгийн хувьд ханшийн уналттай холбоотойгоор өнгөрсөн оноос буурсан дүнтэй гарч байна. Улсын Бүртгэл, Статистикийн Ерөнхий газрын мэдээллээр энэ оны эхний таван сарын дүнгээр экспортоос 222 сая ам.долларын орлого олсон нь өнгөрсөн жилийнхээс 20 сая ам.доллараар буурсан дүн болжээ.